261

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

20 19 .оны 06 дугаар сарын 28.-ны өдөр | Дугаар А/132 | Багануур

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, “Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Багануурын Дулааны станц” ТӨХК-ийн жилийн ажлын тайлан бичих, тайлагнах, дүгнэх журмыг нэгдүгээр хавсралтаар, жилийн ажлын тайлан дүгнэх үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар, жилийн ажлын тайлангийн дүгнэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

Хоёр. Батлагдсан журмыг Захирлын зөвлөлийн гишүүд, хэлтэс, албадын дарга, удирдлагуудад хүргүүлж, танилцуулахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга (Ч.Ариунбаатар)-д даалгасугай.

Гурав. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг компанийн нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 06 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ГАНБААТАР

Тушаал 2018

"Багануурын Дулааны станц" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2019 оны 06-р сарын
28-ны өдрийн А/132 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН БИЧИХ, ТАЙЛАГНАХ, ДҮГНЭХ, ЖУРАМ

Нэг. Зорилго

"Багануурын Дулааны станц" ТӨХК-ийн хэлтэс, албадын жилийн ажилд үнэлэлт дүгнэлт өгөх, хамт олны бүтээлч үйл ажиллагааг идэвхижүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

ХОЁР. ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Жилийн ажлын тайланг дараах дарааллын дагуу тоо, баримттайгаар бичиг хэргийн стандартын дагуу бичиж, Захиргаа, хүний нөөцийн хэлтэст цаасаар болон файлаар дараа оны 01 дүгээр сарын эхний 20 хоногийн дотор хүргүүлсэн байна. Үүнд:

2.1 Тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилт, түүний биелэлт

2.2 Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт

2.3 Тухайн жилийн зорилтот түвшин, түүний биелэлт

2.4 Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, түүний биелэлт

2.5 Шинээр санаачилсан, бүтээлч ажил

2.6 Тухайн оны материалын захиалгын оновчтой байдал

2.7 Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хадгалалт, хамгаалалт

2.8 Улс, нийслэл, дүүрэг, компанийн захиргаанаас хамт олны дунд зохион байгуулсан ажилд оролцсон байдал

2.9 Ажилтнуудаа сургаж хөгжүүлсэн байдал

2.10 Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлжүүлсэн байдал

2.11 Ажлын цаг ашиглалт, сахилга, дэг журам

2.12 Хүний амь эрсэдсэн, бүлэг болон хүнд осол, аваарь гаргасан эсэх

2.13 Аваарь, саатал гаргасан эсэх

2.14 Галын аюулгүй байдлын дүрэм, журмын мөрдөлт

2.15 Хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн эсэх

2.16 Дүгнэлт

2.17 Дараа онд дэвшүүлж буй зорилт

2.18 Ирэх онд Захиргаанд тавьж шийдвэрлүүлэх асуудал, санал

2.19 Тайлантай холбоотой зураг, хүснэгт, график, тоон баримтуудыг хавсаргах

ГУРАВ. ТАЙЛАГНАХ

3.1 Хэлтэс, алба жилийн ажлаа Захирлын зөвлөлийн хуралд дараа оны 01 дүгээр сарын 31-ний дотор тайлагнана.

3.2 Хэлтэс, албадын дарга нар өөрийн биеэр 15 минутанд багтаан ppt /power point/ хэлбэрээр оновчтой, бүрэн тайлагнана.

3.3 Асуулт, хариулт, зөвлөмж, дүгнэлтийг 15 минутанд багтаана.

3.4 Тайлан танилцуулахад хэлтэс, алба, хэсгийн ИТА, мэргэжилтэн нар заавал байлцана.

3.5 Тайлангийн хугацаанд зөвхөн Захирлын зөвлөлийн гишүүд асуулт асууж, зөвлөмж өгөх эрхтэй.

3.6 Тайлангийн хураангуйг цаасан хэлбэрээр Захирлын зөвлөлийн гишүүдэд тараасан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭХ

4.1 Захирлын зөвлөлийн гишүүд хоёрдугаар хавсралт хүснэгтэнд заасан үзүүлэлт тус бүрт өгөх үнэлгээг дараах байдлаар өгнө. Үүнд:

4.1.1 Огт хийгээгүй буюу хангалтгүй үзүүлэлтэнд – 0-59%

4.1.2 Тухайн үзүүлэлт хангалтгүй тохиолдолд – 60-79%

4.1.3 Тухайн үзүүлэлтээ бүрэн хийсэн боловч чанартай гүйцэтгээгүй тохиолдолд 80-89% хүртэл

4.1.4 Тухайн ажлаа бүрэн чанартай гүйцэтгэсэн тохиолдолд 90-100% тус тус өгнө.

4.2 Тухайн нэгжийн жилийн ажлын үнэлгээг Захирлын зөвлөлийн гишүүн тус бүр дүгнэнэ. Тайлан дүгнэхэд оролцсон гишүүн тус бүрийн оноог нэгтгэн, дундаж онооны аргаар тооцон эцсийн дүнг гаргана.

4.3 Үнэлгээ өгсөн гишүүдийн нийт дундаж оноог гарган дараах үнэлгээг өгнө. Үүнд:

4.3.1 Дундаж оноо нь 0-59% бол “Хангалтгүй” үнэлгээ

4.3.2 Дундаж оноо нь 60%-79% бол “Бүрэн бус хангалттай” үнэлгээ

4.3.3 Дундаж оноо нь 80%-89% бол “Хангалттай” үнэлгээ

4.3.4 Дундаж оноо нь 90-100% бол “Бүрэн хангалттай” үнэлгээг тус тус өгнө.

4.4 Хэлтэс, албаны дарга нь тайлан хамгаалалтанд орохыг өмнө дүгнэх үзүүлэлтийн 12, 13, 14 дугаар асуулгыг Хөдөлмөр хамгааллын инженерээр дүгнүүлсэн байна.

4.5 Дараах тохиолдолд тухайн нэгжийн ажлын тайлан сонсож “Хангалтгүй” үнэлгээ өгнө. Үүнд:

4.6.1 Тухайн хэлтэс, албын тайлан 59 ба түүнээс доош оноо авсан бол,

4.6.2 Жилийн эцсийн тайлангаа ирүүлээгүй, мөн хамгаалаагүй бол,

ТАВ. ШАГНАЖ УРАМШУУЛАХ, ХАРИУЦЛАГА ТООЦОХ

5.1 Хангалттай, бүрэн хангалттай үнэлгээгээр дүгнэгдсэн хэлтэс, алба, хэсгийн жилийн ажлын үр дүнгийн шагналыг бүрэн олгоно.

5.2 “Бүрэн бус хангалттай” үнэлэгдсэн хэлтэс, албаны дарга, хэсгийн инженер, ажилтан, албан хаагчдын жилийн ажлын үр дүнгийн шагналыг 79 %-иар тооцон олгоно.

5.3 “Хангалтгүй” үнэлэгдсэн хэлтэс, албаны даргыг албан тушаалаас нь бууруулах, өөр ажилд шилжүүлэх, ажлаас чөлөөлөх хүртэл хариуцлага ногдуулж болно.

5.4 “Хангалтгүй” үнэлэгдсэн хэлтэс, албаны дарга, хэсгийн инженер, ажилтан албан хаагчдын жилийн ажлын үр дүнгийн шагналыг 59 %-иар тооцон олгоно.

"Багануурын Дулааны станц" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2019 оны 06-р сарын
28-ны өдрийн А/132 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

..... ЖИЛИЙН АЖЛЫН
ТАЙЛАН ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон оноо
1	Тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилт, түүний биелэлт	0-100	
2	Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт /үйлдвэрлэлийн жилийн төлөвлөгөө биелээгүй нь тус станц буюу тухайн нэгжээс хамааралгүй бол тооцохгүй/	0-100	
3	Тухайн жилийн зорилтот түвшин, түүний биелэлт	0-100	
4	Тухайн онд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт	0-100	
5	Шинээр санаачилсан, бүтээлч ажил	0-100	
6	Тухайн оны материалын захиалгын оновчтой байдал	0-100	
7	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт	0-100	
8	Улс, нийслэл, дүүрэг компанийн захиргаанаас хамт олны дунд зохион байгуулсан ажилд оролцсон байдал	0-100	
9	Ажилтнуудаа сургаж хөгжүүлсэн байдал	0-100	
10	Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэлжүүлсэн байдал	0-100	
11	Ажлын цаг ашиглалт, сахилга, дэг журам	0-100	
12	Хүний амь эрсэдсэн, бүлэг болон хүнд осол, аваарь гаргасан эсэх	0-100	
13	Аваарь, саатал гаргасан эсэх	0-100	
14	Галын аюулгүй байдлын дүрэм журмын мөрдөлт	0-100	
15	Хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн эсэх	0-100	
	Дундаж хувь		

ДҮГНЭСЭН:

ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН ..... / /

"Багануурын Дулааны станц" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2019 оны 06-р сарын
28-ны өдрийн А/132 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

..... ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

№	Үзүүлэлт	Захирлын зөвлөлийн гишүүдийн үнэлгээний нэгтгэл											Нэгдсэн дүн	Дундаж оноо
		Гүйцэтгэх захирал	Дэд захирал	ЗХНХ-ийн дарга	СЭЗБХ-ийн дарга	УА-ны дарга	ДШСА-ны дарга	Хуулийн зөвлөх, а/э	ЗЦГ-ын инженер	Дотоод аудитор	Хэмнэлтийн менежер	Эдийн засагч		
1	Тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилт, түүний биелэлт													
2	Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт /үйлдвэрлэлийн жилийн төлөвлөгөө биелээгүй нь тус станц буюу тухайн нэгжээс хамааралтай бол тооцохгүй/													
3	Тухайн жилийн зорилтот түвшин, түүний биелэлт													
4	Тухайн онд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт													
5	Шинээр санаачилсан, бүтээлч ажил													
6	Тухайн оны материалын захиалгын оновчтой байдал													
7	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт													
8	Улс, нийслэл, дүүрэг компанийн захиргаанаас хамт олны дунд зохион байгуулсан ажилд оролцсон байдал													
9	Ажилтнуудаа сургаж хөгжүүлсэн байдал													
10	Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэлжүүлсэн байдал													
11	Ажлын цаг ашиглалт, сахилга, дэг журам													
12	Хүний амь эрсэдсэн, бүлэг болон хүнд осол, аваарь гаргасан эсэх													
13	Аваарь, саатал гаргасан эсэх													
14	Галын аюулгүй байдлын дүрэм журмын мөрдөлт													
15	Хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн эсэх													
	Дүн													
	Нийт дундаж оноо													

НЭГТГЭСЭН:

ГИШҮҮН ..... / /